



ХАЛДВАРТ ӨВЧИИ  
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Төлбөрт тусламж, үйлчилгээний журам,  
үнийн жишиг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24.1, 24.2, 24.5 дугаар заалтууд, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5 заалтууд, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2 дугаар заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49А/118 дугаар тушаал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын бүтэц, санхүүжилтын журмыг нэгдүгээр, "Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49А/118 дугаар тушаалд тусгагдсан болон шинэ технологийн нэмэлтээр хийгдэх тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф"-ыг хоёрдугаар, Нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тарифыг гуравдугаар, Урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогооны журмыг дөрөвдүгээр, Үндэсний чанарын гадаад хяналтын материал болон баталгаажуулах шинжилгээний жагсаалт, тарифыг тавдугаар хавсралтаар тус тус баталж 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Тусламж, үйлчилгээний журмыг төвийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг нийт тасаг албадын эрхлэгч, дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга (Б.Батсүх)-д, төлбөртэй тусламж, үйлчилгээнээс орсон орлогыг төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг тооцож ажиллахыг Санхүү бүртгэлийн алба (Г.Хунзаяа)-д тус тус даалгасугай.
4. Энэхүү журам гарсантай холбогдуулан ерөнхий захирлын 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/151 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.Билэгтсайхан

Ц.БИЛЭГТСАЙХАН

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 09 дүгээр сарын 9 өдрийн  
№... тоот тушаалын нэгдүгээр хавсралт

1/184



## ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү журмаар Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-өөс үйлчлүүлэгчдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх харилцааг зохицуулна. Доорх 4 ангилалд хамаарах үйлчилгээнүүдийг Төлбөрт тусламж, үйлчилгээнд хамааруулж байна. Үүнд:

1.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан Үйлчлүүлэгч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан “ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-д заасан иргэн хариуцах төлбөр, ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4.4, 4.5 дэх заалтууд дахь нөхцөл үүссэн тохиолдолд;

1.2 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49А/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт болох “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”-нд заагдсан Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

1.3 Эрүүл мэндийн даатгалгүй, өөрийн хүсэлтээр шатлал алгассан Үйлчлүүлэгч (иргэн, аж ахуй нэгж, байгууллага)-ийн хүсэлтээр үзүүлэх тусламж, үйлчилгээ;

1.4 Донтолт, архидалт, мансуурлаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, Иргэн санаатайгаар амь насаа өгүүтгэхээр оролдсон, ЭМД-аас санхүүжүүлэхгүй шинээр нэвтэрч буй технологийн шинэчлэлт хийгдсэн тусламж, үйлчилгээ зэргийг тус тус төлбөртэй үзүүлнэ.

### ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ОРЛОГЫГ БҮРТГЭХ, ТӨСӨВТ ТУСГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон үнийн жишгийг үйлчлүүлэгчдэд ил тод харагдахуйц талбайд байршуулах, байгууллагын цахим сайтад байршуулах ба төлбөрийн талаарх бүхий л лавлагааг цахим бүртгэлийн бүртгэгч болон хөтөч нар хариуцан ажиллана.

2.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг бэлэн болон бэлэн бусаар төвийн кассаар дамжуулан хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэх, эмнэлгийн цахим бүртгэлийн болон санхүүгийн программыг ашиглан төрийн сан дахь төвийн төсвийн харилцах дансанд төвлөрүүлэх ажлыг Санхүү бүртгэлийн алба хариуцан зохион байгуулж ажиллана.

2.3. Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр хийгдээгүй үзлэг, үйлчилгээний төлбөрийг буцаах тохиолдолд тухайн үйлчлүүлэгчийн өргөдлийг үндэслэн төлбөрийг буцааж олгоно.

2.4. Иргэдийн төлбөр төлсөн баримтад байгууллагын нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээний нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөгдөх хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.5. Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлдэг тасаг, нэгжүүдэд ерөнхий захирлын тушаалаар батлагдсан тарифын мэдээлэл болон төлбөрийн тооцооны зөрчлийн эрсдлээс хамгаалах санамж бичгийг заавал байрлуулна.

### ГУРАВ. БУСАД

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-д ороогүй оношийн бүлэг бүхий тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд хамаарахгүй учир төлбөрийг үйлчлүүлэгч 100 хувь төлнө.

3.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны 01 дүгээр тогтоолын 4.2 дахь заалтанд тусгагдсан иргэд хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн тусламж, үйлчилгээний хамтын төлбөрүүдээс 100 хувь хөнгөлөгдөнө. Үүнд:

- 0-18 насны хүүхэд;
- Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн;
- Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;
- Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;
- Ял эдэлж байгаа ялтан;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

3.3. ЭМДЕГ болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан гэрээгээр тохиролцсон эрүүл мэндийн даатгалын зарим тусламж, үйлчилгээний тариф болон тухайн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээний зөрүү төлбөрийг үйлчлүүлэгч төлнө.

3.4. Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн дараах тусламж, үйлчилгээний зардлыг тухайн иргэн эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран ЭМД-ын сангаас бүрэн хариуцна. Үүнд:

- Яаралтай тусламж;
- Түргэн тусламж;
- Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал;
- Халдварт өвчний оношилгоо, эмчилгээ;
- Сэтгэцийн эмгэгийн зарим тусламж, үйлчилгээ орно. Үйлчлүүлэгчээс тусламж үйлчилгээтэй холбоотой төлбөрийг хураан авахыг хатуу хориглоно.

3.5. Даатгуулагч "Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц"-ын тусламж, үйлчилгээг бүрэн аваагүй буюу өөрийн буруугаас давтан үзлэгт ороогүй бол дараагийн шатанд энэ журмын 4.4-т зааснаас бусад тусламж,

үйлчилгээ авах тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний нийт зардлын 25 хувийг төлнө.

3.6. Эмчийн заалт, илгээх бичиггүйгээр иргэн сайн дураараа шатлал алгасан ХӨСҮТ-ийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан, оношилгоо, шинжилгээ /өндөр өртөгт болон бусад/ хийлгэсэн бол тухайн тусламж, үйлчилгээний зардлыг ОХБ /оношийн хамааралтай бүлэг/-ийн жагсаалтад заасан хэмжээгээр төлнө. Хэрэв тусламж, үйлчилгээ нь ОХБ-ийн жагсаалтад ороогүй бол төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний жишиг хэмжээ"-ээр тооцож төлнө.

3.7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй даатгуулагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа тухайн тусламж, үйлчилгээний нийт төлбөрийн 80 хувьтай тэнцэх төлбөрийг төлнө.

3.8. Шинээр авах тоног төхөөрөмжтэй холбоотойгоор тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх тохиолдолд тусламж, үйлчилгээний өртгийг тооцон журамд нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулна.

3.9. Тухайн жилд 3-аас дээш удаа шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд 4 дэх тохиолдлоос эхлэн төлбөрийг ОХБ-ийн жагсаалтад заасан хэмжээгээр төлбөрийг төлнө.

#### ДӨРӨВ. НЭМЭЛТ, НӨХЦӨЛ САЙЖРУУЛСАН ТӨЛБӨРТЭЙ ӨРӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Төлбөрт орны тоо нь төвийн батлагдсан нийт орны 10%-иас илүүгүй байна.

4.2. Үйлчлүүлэгч төлбөрт орны төлбөрийг амбулаторийн кассанд тушаана.

4.3. Тасаг нэгжүүд төлбөрт орны мэдээ, тайланг сар бүр гаргаж Санхүү бүртгэлийн албаар хянуулна.

4.4. Хяналтын дүнгийн талаарх мэдээллийг Санхүү бүртгэлийн алба нь Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захиралд мэдээллийн урсгал хэлбэрээр сард нэг удаа тогтмол танилцуулна.

4.5. Тус төвийн дотоод журмыг зөрчсөн, ёс зүй харилцаа хандлагын асуудал гаргасан үйлчлүүлэгчийн төлбөрийг буцаан олгохгүй.

#### ТАВ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, БУСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49А/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 722 дахь жагсаалтын дагуу Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тухайн тусламж, үйлчилгээний өртгийн нийт дүнгээр гэрээ байгуулан үйлчилнэ.

5.2. Аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээгээр гүйцэтгэх урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг Амбулаторийн эрхлэгч, лабораторийн

шинжилгээг Нэгдсэн лабораторийн албаны дарга, оношилгоонд **Өндөр зүйл** тасгийн эрхлэгч нар тус тус хариуцан зохион байгуулна.

5.3. Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах аж ахуйн нэгж, байгууллага нь захиалгаа төвийн захиргаанд албан бичгээр өгч, улмаар холбогдох гэрээг байгуулж, баталсан хуваарийн дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

5.4. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог тогтоосон хугацаанд төвийн дансанд шилжүүлнэ.

5.5. Урьдчилан сэргийлэх үзлэгийн тайланг амбулаторийн эрхлэгч нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирлаар хянуулан Санхүү бүртгэлийн албанд хагас, бүтэн жилээр тайлагнана.

### ЗУРГАА. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

6.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, зарцуулалтын үнэлгээний дотоодын хяналт, шинжилгээг дотоод аудитын ажилтан хариуцан танилцуулна. .

6.2 Төлбөрт тусламж, үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдлын талаарх тайланг дотоод аудит хариуцсан ажилтан хүлээнэ.

### ДОЛОО. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1. "Эрүүл мэндийн тухай" хуулийн 24.6 дугаар зүйлд заасан тусламж, үйлчилгээ буюу "Төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээ"-г авч буй иргэнээс төлбөр авах;

7.2. ЭМД-ын сангаас оношилгоо, шинжилгээнд олгож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авах;

7.3. Үйлчлүүлэгчдээс жагсаалтанд зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, эмч, мэргэжилтнүүд иргэдтэй шууд төлбөр тооцоо хийх;

7.4. Ажлын байрандаа эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодис худалдаалах;


7.5. Иргэдээс нөмрөг, улавч, бие засах газар, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахыг тус тус хориглоно.

### НАЙМ. ЖУРАМ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

9.1. Энэхүү журам зөрчсөн албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд төвийн хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтын дагуу сахилгын арга хэмжээ авна.

9.2. Эмнэлгийн удирдлага эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэх боломжгүй, эрүүгийн шинжтэй тохиолдолд холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
 2022 оны 08 дүгээр сарын 09 өдрийн  
 11/184 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ТАРИФ

№	Шинжилгээний нэр	Шинжилгээний арга	Төлбөрийн хэмжээ
<b>Нэг: Лабораторийн шинжилгээ</b>			
<b>Клиник химийн шинжилгээ</b>			
1.1.1	Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, (13 үзүүлэлт)	LabuStrip test	6,000
1.1.2	Тархи нугасны шингэний ерөнхий шинжилгээ	XN 550, cobas c 501	30,000
1.1.3	Шүүдэст шингэний ерөнхий шинжилгээ	XN 550, cobas c 502	30,000
1.1.4	(TBIL) Нийт билирубин Total bilirubin	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.5	(DBIL) Билирубин шууд	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.6	(AST) АСАТ	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.7	(ALAT) АЛАТ	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.8	(ALB) Альбумин Albumin	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.9	(TP) Нийт уураг Total protein	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.10	(CREA) Креатинин Creatinine	Cobas C311, Integra I 400, Cobas C501	4,000
1.1.11	(GLU) Глюкоз Glucose	Cobas C311, Integra I 400, Cobas C501	3,000
1.1.12	(ALP) Шүлтлэг фосфотаза, Alkaline phosphatase	Cobas C311, Integra I 400, Cobas C501	4,000
1.1.13	(AMY) Амилаза alpha Amylase	Cobas C311, Integra I 400, Cobas C501	5,000
1.1.14	(AMY-P) Нойр булчирхайн амилаза Pancrease amylase	Cobas C311, Integra I 400, Cobas C501	6,000

1.1.1 5	Липаза (Lipase)	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	6,000
1.1.1 6	(Т-СНО) Холестерин Total Cholesterine	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.1 7	(ТРУС) Нийт уураг (Нугасны усанд)	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	6,000
1.1.1 8	(GGT) ГГТ Гамма- глутамилтрансфераза	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.1 9	(UA) Шээсний хүчил Urid acid (цусанд)	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.2 0	(Urea) Мочевин	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.2 1	(LDH) ЛДГ Lactic dehydrogenase	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.2 2	(Fe) Төмөр Iron	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.2 3	(P) Фосфор Phosphate	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.2 4	(Mg-2) Магни Magnesium	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.2 5	(Ca) Кальци Calcium	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.2 6	(Na) Натри Sodium	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	5,000
1.1.2 7	(K) Кали Potassium	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	5,000
1.1.2 8	(TG) Триглицерид Triglycerid	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.2 9	(Cl) Хлор-Chloride	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	5,000
1.1.3 0	(HDL) Их нягтралтай липопротеин High density lipoprotein	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	6,000
1.1.3 1	(LDL) Бага нягтралтай липопротеин Low density lipoprotein	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	10,000
1.1.3 2	(ASLO) Антистрептолизин antistreptolysin-тоон үзүүлэлт	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	10,000

1.1.3 3	(CRP) С урвалжийн уураг C reactive protein-тоогоор	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	11,000
1.1.3 4	(RF) Ревматоид фактор Rheumatoid factor-тоогоор	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	9,000
1.1.3 5	(HbA1c) Глюкозжсон гемоглобин	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	17,000
1.1.3 6	(Ferr) Ферритин-Ferritin	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	20,000
1.1.3 7	Лактат-Lactate (сийвэнд)	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	5,000
1.1.3 8	(D-Dimer) Д-Даймер	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	60,000
1.1.3 9	(PT) Pro-thrombine time, Протромбины хугацаа	STA compact		5,000
1.1.4 0	(APTT) Activated Partial Thromboplastin Time, Зориуд идэвхижүүлсэн протромбины хугацаа	STA compact		5,000
1.1.4 1	(Fibrinogen) Фибриноген	STA compact		6,000
1.1.4 2	(TT) Thrombin time, Тромбины хугацаа	STA compact		5,000
1.1.4 3	(INR) International normalized ratio, Олон улсын норматив харьцаа	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	5,000
1.1.4 4	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (30 үзүүлэлт) (CBC-DIFF)	XN 550, Pentra XLR		14,000
1.1.4 5	УЭТХ (Улаан эсийн тунах хурд), СОЭ-(ESR)	Автомат пипетик		4,500
1.1.4 6	Ретикулоцит тоолох (анализатораар)	XN 550		20,000
1.1.4 7	Цусны бүлэг, резус фактор (ABO+RhD) Blood group, rhesys factor	ЦНШБУ		11,000
1.1.4 8	Цусны хувийн тохироо	ЦНШБУ		15,000
1.1.4 9	Шээсэнд тунадас үзэх	Бүрэн автомат анализатор		10,000
1.1.5 0	Глюкоз (GLU- Glucose) /Нугасны усанд/	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.5 1	Глюкоз (GLU- Glucose) /Плеврийн шингэнд/	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	3,000
1.1.5 2	Лактат /Нугасны усанд/	Cobas Integra I Cobas C501	C311, 400,	4,000
1.1.5 3	ЛДГ-Лактат дегидрогеназа (LDH-Lactic dehydrogenase) плеврийн шингэнд	Cobas Integra I	C311, 400,	3,000



		Cobas C501	
1.1.5 4	Нийт уураг (Плеврийн шингэнд)	Cobas Integra I Cobas C501	C311, 400, 3,000
1.1.5 5	Нугасны шингэнд хлор үзэх	Cobas Integra I Cobas C501	C311, 400, 5,000
1.1.5 6	Цусны хийн шинжилгээ	Хийн анализатор	28,000
1.1.5 7	Шүүдэст шингэний ерөнхий шинжилгээ	-	30,000
<b>1.2 Хепатит энтеровирусийн шинжилгээ</b>			
1.2.1	Гепатитын А вирусийн цөмийн эсрэг биеийн М уураг (Anti-HAV-IgM)	ELISA	20,000
1.2.2	Гепатитын А вирусийн цөмийн эсрэг биеийн М уураг электрохимолюминесценц (Anti-HAV IgM)	Cobas E411/ECLIA	35,000
1.2.3	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгчийн үзүүлэлт (HBsAg)	ELISA	10,000
1.2.4	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгчийн үзүүлэлт электрохимолюминесценц (HBsAg)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	15,000
1.2.5	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгчийн үзүүлэлтийг тоолох аргаар үзэх электрохимолюминесценц (HBsAg quant)	Cobas E411/ECLIA	60,000
1.2.6	В вирусийн гадаргуугийн эсрэг бие электрохимолюминесценц (аНВс)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	25,000
1.2.7	В вирусийн цөмийн эсрэг бие (аНВс)	ELISA	10,000
1.2.8	В вирусийн цөмийн эсрэг бие электрохимолюминесценц (аНВс)	Cobas E411/ECLIA	19,000
1.2.9	Гепатитын В вирусийн цөмийн эсрэг биеийн М уураг (anti-HBc IgM)	ELISA	10,000
1.2.1 0	Гепатитын В вирусийн цөмийн эсрэг биеийн М уураг электрохимолюминесценц (anti-HBc IgM)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	35,000
1.2.1 1	В вирусийн Е эсрэгтөрөгч (HBeAg)	ELISA	15,000
1.2.1 2	В вирусийн Е эсрэгтөрөгч электрохимолюминесценц (HBeAg)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	30,000
1.2.1 3	В вирусийн Е эсрэг бие (аНВе)	ELISA	15,000
1.2.1 4	В вирусийн Е эсрэг бие электрохимолюминесценц (аНВе)	Cobas E411/ECLIA	25,000
1.2.1 5	Элэгний В вирусийн ДНХ тоолох (HBV-DNA)	бх-ПГУ / Real-time PCR	133,000
1.2.1 6	С вирусийн эсрэг эсрэг бие (аНCV)	ELISA	10,000

1.2.1 7	С вирусийн эсрэг эсрэг бие электрохимолюминесценц (aHCV)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	25,000
1.2.1 8	С гепатитийн баталгаажуулах RIBA арга	Иммуноблотын арга	225,000
1.2.1 9	Элэгний С вирусийн PHX тоолох HCV- RNA	бх-ПГУ/Real-time PCR	139,000
1.2.2 0	D вирусийн эсрэг эсрэг бие (anti HDV)	ELISA	15,000
1.2.2 1	D вирусийн эсрэг эсрэг бие электрохимолюминесценце (anti HDV)	ELISA	25,000
1.2.2 2	D вирусийн эсрэг биеийн M уураг (anti HDV IgM)	ELISA	25,000
1.2.2 3	Элэгний D вирусийн PHX тоолох (HDV- RNA)	бх-ПГУ/Real-time PCR	163,000
1.2.2 4	Хепатит E вирусийн эсрэг иммуноглобулин M (anti-HEV IgM)	ELISA	20,000
1.2.2 5	Элэгний хавдрын маркер (AFP)	Cobas E411/ECLIA, Maglumi 800/ECLIA	20,000
1.2.2 6	Helicobacter pylori IgM	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.2 7	D-Dimer	Maglumi 800/ECLIA	60,000
1.2.2 8	Витамин D нийт	Maglumi 800/ECLIA	40,000
1.2.2 9	Бөөмийн эсрэг бие /ANA нийт/	Maglumi 800/ECLIA	24,000
1.2.3 0	Anti-ds DNA электрохимолюминесценц	Maglumi 800/ECLIA	25,000
1.2.3 1	Ийлдэсний С урвалжийн уураг электрохимолюминесценц (CRP)	Maglumi 800/ECLIA	45,000
1.2.3 2	Ферритин (Ferritin)	Maglumi 800/ECLIA	26,000
1.2.3 3	Прокальцитонин (PCT)	Maglumi 800/ECLIA	85,000
1.2.3 4	Тропонин I (Troponin I)	Maglumi 800/ECLIA	35,000
1.2.3 5	Энгийн херпес вирус 1-ийн хурц халдвар (HSV-1 IgM)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.3 6	Энгийн херпес вирус 1-ийн архаг халдвар (HSV-1 IgG)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.3 7	Энгийн херпес вирус 2-ийн хурц халдвар (HSV-1 IgM)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.3 8	Энгийн херпес вирус 2-ийн архаг халдвар (HSV-1 IgG)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.3 9	Энгийн херпес вирус-1/2 электрохимолюминесценц (HSV-1/2 IgM)	Maglumi 800/ECLIA	60,000
1.2.4 0	Энгийн херпес вирус 6-ийн хурц халдвар (HSV-6 IgM) (Human herpes virus-6 IgM (HHV-6))	ELISA	10,000
1.2.4 1	PIVKA II	Maglumi 800/ECLIA	60,000

1.2.4 2	Цитомегаловирусын хурц халдвар (CMV IgM)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.4 3	Цитомегаловирусын архаг халдвар (CMV IgG)	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.4 4	EBV VCA IgM	Maglumi 800/ECLIA	30,000
1.2.4 5	Улаанууд вирусийн хурц халдвар электрохимолюминесценц (Rubella-IgM)	Maglumi 800/ECLIA	23,000
1.2.4 6	Улаанууд вирусийн архаг халдвар электрохимолюминесценц (Rubella-IgG)	Maglumi 800/ECLIA	23,000
1.2.4 7	Токсоплазм вирусийн хурц халдвар электрохимолюминесценц (Тохо IgM)	Maglumi 800/ECLIA	22,000
1.2.4 8	Токсоплазм вирусийн архаг халдвар электрохимолюминесценц (Тохо IgG)	Maglumi 800/ECLIA	22,000
1.2.4 9	TORCH халдвар (Toxoplasma, Rubella virus, Cytomegalovirus, Herpes simplex virus)	Maglumi 800/ECLIA	35,000
		Багцаар	160,000
1.2.5 0	Салхин цэцэг-могой яр вирусын иммуноглобулин (Varicella Zoster Virus IgM)	ELISA	30,000
1.2.5 1	Coxsackievirus A16 иммуноглобулин M (CoxV A16 IgM)	ELISA	15,000
1.2.5 2	Coxsackie Virus A16 PHX илрүүлэх	бх-ПГУ (чанарын)/Real-time PCR (qualitative)	60,000
1.2.5 3	Нарийн гэдэсний вирусийн иммуноглобулин M (Enterovirus IgM)	ELISA	10,000
1.2.5 4	Нарийн гэдэсний 71 вирусийн иммуноглобулин M (Enterovirus 71 IgM)	ELISA	15,000
1.2.5 5	Нарийн гэдэсний 71 вирус (Enterovirus 71)	бх-ПГУ (чанарын)/Real-time PCR (qualitative)	80,000
1.2.5 6	SARS-CoV-2 Ab	ELISA	25,000
1.2.5 7	SARS-CoV-2 IgM	ELISA	25,000
1.2.5 8	Anti-SARS-Cov-2-N электрохимолюминесценц	Cobas E411/ECLIA	30,000
1.2.5 9	Anti-SARS-Cov-2-S электрохимолюминесценц	Cobas E411/ECLIA	60,000
1.2.6 0	COV-2 Neutralizing Antibody	Maglumi 800/ECLIA	45,000
1.2.6 1	COV-2 RBD IgG	Maglumi 800/ECLIA	45,000
1.2.6 2	Anti-SARS-CoV-2 IgM электрохимолюминесценц	Maglumi 800/ECLIA	45,000

1.2.6 3	Anti-SARS-CoV-2 IgG электрохимолюминесценц	Maglumi 800/ECLIA	45,000
1.2.6 4	COVID-19 IgM/IgG Plus	Түргэвчилсэн тест	15,000
<b>1.3 Нян судлалын шинжилгээ</b>			
1.3.1	Бичил амь судлалын шинжилгээ: (Хамар залгиур, Хеөмий гүйлсэн булчирхай, Шарх, Нүд, Чихний арчдас, Цус, Өтгөн, Цэр, Бөөлжис, Ходоодны угаадас, Буглаа, Умайн арчдас, Үрийн шингэн, цес, Катетр, гуурс)	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга	32,000
1.3.2	Бичил амь судлалын шинжилгээ: (Хамар залгиур, Хеөмий гүйлсэн булчирхай, Шарх, Нүд, Чихний арчдас, Цус, Өтгөн, Цэр, Бөөлжис, Ходоодны угаадас, Буглаа, Умайн арчдас, Үрийн шингэн, цес, Катетр, гуурс)	Нэмэлтээр Vitek бүрэн автомат анализатораар шинжилсэн тохиолдолд	72,000
1.3.3	Биеийн шингэний ариун чанар үзэх (Тархи нугасны шингэн, Хэвлийн шингэн, цус, Плеврийн шингэн, Перикардын шингэн, Үений шингэн, шээс, хоолойн арчдас, биопси.)	Vitek бүрэн автомат анализатораар шинжилнэ	72,000
1.3.4	Хүүхдийн байгууллагад гарсан суулгалтат халдварын голомт илрүүлэх (Өтгөн, шулуун гэдэсний арчдас)	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга	32,000
1.3.5	Хүүхдийн байгууллагад гарсан суулгалтат халдварын голомт илрүүлэх (Өтгөн, шулуун гэдэсний арчдас)	Нэмэлтээр Vitek бүрэн автомат анализатор, бх- ПГУ/Real-time PCR-аар шинжилсэн тохиолдолд	72,000
1.3.6	Суулгалтат болон хоол хүнстэй холбоотой халдварын үүсгэгч илрүүлэх	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга	32,000
1.3.7	Суулгалтат болон хоол хүнстэй холбоотой халдварын үүсгэгч илрүүлэх	Нэмэлтээр Vitek бүрэн автомат анализатор, шинжилсэн тохиолдолд	72,000
1.3.8	Суулгалтат болон хоол хүнстэй холбоотой халдварын үүсгэгч илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	150,000

1.3.9	Менингит халдварын нян тээгч илрүүлэх (Хамар залгиурын арчдас)	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга	32,000
1.3.10	Менингит халдварын нян тээгч илрүүлэх (Хамар залгиурын арчдас)	Нэмэлтээр Vitek бүрэн автомат анализатораар шинжилсэн тохиолдолд	72,000
1.3.11	Бруцелла нян илрүүлэх (цус, үений шингэн)	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга, нэмэлтээр Vitek бүрэн автомат анализатораар шинжилнэ	120,000
1.3.12	Нян тээгчийн шинжилгээ	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт арга	30,000
1.3.13	MRSA илрүүлэг	Vitek бүрэн автомат анализатораар шинжилсэн тохиолдолд	72,000
1.3.14	MRSA илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	150,000
1.3.15	Тархи нугасны шингэнд эмгэгтөрөгч илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	150,000
1.3.16	Цусанд эмгэгтөрөгч илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	150,000
1.3.17	Бруцелла илрүүлэг	Цус наалдуулах урвал	15,000
1.3.18	Brucella IgM	ELISA	35,000
1.3.19	Brucella IgG	ELISA	35,000
1.3.20	Цусанд хеликобактерийн эсрэгбие тоогоор илрүүлэх (H.Pylori IgM, IgG)	ELISA	36,000
1.3.21	Өтгөнд хеликобактер-ийн эсрэгтөрөгч H.Pylori Ag илрүүлэх	ELISA	20,000
1.3.22	Өтгөнд H.Pylori Ag илрүүлэх	Түргэвчилсэн тест	16,500
1.3.23	Өтгөнд далд цус илрүүлэх	Түргэвчилсэн тест	12,000

1.3.2 4	Нутгийн омгийн өсгөвөр бэлтгэж өгөх	Өсгөвөрлөж, ялган дүйх, Антибиотик мэдрэг чанар тодорхойлох, Vitek анализатор, бх-ПГУ-аар шинжлэх	110,000
1.3.2 5	Тэжээлт орчин бэлтгэж өгөх	Бэлтгэсэн тэжээлт орчин: /1 петрийн аяга/	1,200
1.3.2 6	Өсгөвөр баталгаажуулах шинжилгээ	Өсгөвөрлөж, ялган дүйх, Антибиотик мэдрэг чанар тодорхойлох, Vitek анализатор, бх-ПГУ-аар шинжлэх	110,000
1.3.2 7	Bacillus cereus илрүүлэх	Нян судлал	8,000
<b>1.4 Вирус судлалын шинжилгээ</b>			
1.4.1	Томуугийн А хэвшинж илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	66,000
1.4.2	Томуугийн А хэвшинжийн А(Н1N1) РНХ илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.3	Томуугийн А хэвшинжийн А(Н3N2) РНХ илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	66,000
1.4.4	Томуугийн А хэвшинжийн А(Н5N1) РНХ илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.5	Томуугийн А хэвшинжийн А(Н7N9) РНХ илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.6	Томуугийн В хэвшинж илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.7	Улиралын короновирусийн NL63, OC43, 229E, HKU1 дэд хэвшинжүүд илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.8	Амьсгалын замын синцитиаль вирусийн А,В хэвшинж	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.9	Хүний метапневмовирусийн А,В хэвшинж	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 0	Риновирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 1	Адиновирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 2	Бокавирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 3	Энтеровирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 4	Парэховирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 5	Иж томуугийн 1,2,3,4, дүгээр хэвшинжийн вирус	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 6	Mycoplasma pneumoniae/микоплазм пневмония	бх-ПГУ/Real-time PCR	110,000


1.4.1 7	Улаанбурханы вирусн нуклейн хүчил илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.1 8	Улаанбурханы вирусн халдвар (Measles virus IgM, IgG)	ELISA	15,000
1.4.1 9	Улаанууд вирусн хурц халдвар (Rubella IgM)	ELISA	17,500
1.4.2 0	Улаанууд вирусн архаг халдвар (Rubella IgG)	ELISA	17,500
1.4.2 1	Улаануудын вирусн нуклейн хүчил илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.2 2	Гахай Хавдарын вирусн нуклейн хүчил илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.2 3	Гахай Хавдарын вирусн хурц халдвар (Mumps virus IgM)	ELISA	15,000
1.4.2 4	Парвовирусн хурц халдвар (Parvovirus IgM)	ELISA	15,000
1.4.2 5	Хүний херпес вирусн ДНХ илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.2 6	Ковид-19 (COVID-19/SARS CoV-2) вирусн РНХ илрүүлэх (өвчний учир)	бх-ПГУ/Real-time PCR	35,000
1.4.2 7	Ковид-19 (COVID-19/SARS CoV-2) вирусн РНХ илрүүлэх	Түргэвчилсэн тест	15,000
1.4.2 8	Monkeybox халдвар илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.4.2 9	NGS шинжилгээний 1-р шат ПГУ	Нуклейнхүчил олшируулах	250,000
1.4.3 0	NGS шинжилгээний 2-р шат Library бэлтгэх	Library бүтээгдэхүүн гарган авах	250,000
1.4.3 1	NGS шинжилгээний 3-р шат Qubit хэмжилт	Нукленхүчил, уургийн концентраци хэмжих	50,000
1.4.3 2	NGS шинжилгээний 4-р шат Картридж ашигласан iSeq100 багажийн шинжилгээ (Багадаа 8 сорьц шинжилнэ)	Генийн дараалал тогтоох	5,200,000
1.4.3 3	Сиквинсийн NGS шинжилгээ 5 шат	Дата боловсруулах	1,000,000
<b>1.5 Бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээ</b>			
1.5.1	ХДХВ/ДОХ илрүүлэг	ELISA	25,000
1.5.2	ХДХВ/ДОХ илрүүлэг	PCR-GX	120,000
1.5.3	ХДХВ/ДОХ илрүүлэг	Serodia/HIV	30,000
1.5.4	ХДХВ/ДОХ баталгаажуулах	Western Blot	350,000
1.5.5	ДОХ-ын вирусн ачаалал тоолох (HIV Viral load)	RT-PCR/HIV	150,000
1.5.6	Тэмбүү өвчний илрүүлэг	Syphilis TP-IgG ELISA	15,000
1.5.7	Тэмбүү өвчний илрүүлэг, хурдавчилсан ийлдсийн реаген төст	RPR	8,000
1.5.8	Тэмбүү өвчний илрүүлэг	Syphilis VDRL	7,000
1.5.9	Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил	TPHA	5,000

1.5.1 0	Тэмбүү өвчнийг баталгаажуулах	Syphilis TP-IgM ELISA	35,000
1.5.1 1	Тэмбүү өвчнийг баталгаажуулах	Syphilis TP-PA Serodia	13,000
1.5.1 2	Тэмбүү өвчнийг баталгаажуулах	Syphilis FTA-bs	45,000
1.5.1 3	Тэмбүү өвчнийг баталгаажуулах	Syphilis HISCL-TP ab /Хемилюминесцен сийн аргаар тэмбүү өвчний нийт эсрэг бие илрүүлэх/	30,000
1.5.1 4	БЗДХ-ын нян судлалын шинжилгээ	Бичил харуур	10,000
1.5.1 5	БЗДХ-ын нян судлалын шинжилгээ	Өсгөвөрлөх, ялган дүйх, АМЧ, API, Vitek	32,000
1.5.1 6	Микоплазм, уреоплазм ID, AST	Өсгөвөр	30,000
1.5.1 7	Мөөгөнцөр илрүүлэх		28,000
1.5.1 8	Трихомонад өсгөвөрлөх	Өсгөвөр	30,000
1.5.1 9	БЗДХ-ын нян судлалын баталгаажуулах шинжилгээ	Наац, өсгөвөр	40,000
1.5.2 0	БЗДХ-ын үндсэн 7 үүсгэгч: Trichomonas vaginalis (TV), Mycoplasma hominis (MH), Mycoplasma genitalium (MG), Chlamydia trachomatis (CT), Neisseria gonorrhoeae (NG), Ureaplasma parvum (UP), Ureaplasma urealyticum (UU)	бх-ПГУ/Real-time PCR	165,000
1.5.2 1	Бэлгийн замын шархлаат халдварын 7 үүсгэгч Herpes simplex virus type 1 (HSV1), Herpes simplex virus type 2 (HSV2), Cytomegalovirus (CMV), Varicella-zoster virus (VZV), Lymphogranuloma venereum (LGV), Treponema pallidum (TP), Haemophilus ducreyi (HD)	бх-ПГУ/Real-time PCR	140,000
1.5.2 2	Мөөгөнцөрт халдварын 7 үүсгэгч: (Candida albicans (CA), Candida glabrata (CG), Candida tropicalis (CTp), Candida parapsilosis (CP), Candida krusei, Candida dubliniensis (CD), Candida lusitaniae (CL)	бх-ПГУ/Real-time PCR	140,000
1.5.2 3	Нянгийн гаралтай үрэвсэл 7 үүсгэгч: Gardnerella vaginalis (GV), Atopobium vaginae (AV), Megaspheera Type 1 (Mega1), Bacterial vaginosis-associated bacteria 2 (BVAB2), Mobiluncus spp (Mob), Bacteroides fragilis (BF),	бх-ПГУ/Real-time PCR	140,000




	Lactobacillus spp (Lacto)		
1.5.2 4	Папиллома вирусийн (HPV) 28 хэв шинж: Өндөр эрсдэлт 19 хэв шинж (16,18,26,31,33,35,39,45,51,52,53,56,58,59,66,68,69,73,82) бага эрсдэлт 9 хэв шинж (6,11,40,42,43,44,54,61,70)	бх-ПГУ/Real-time PCR	165,000
1.5.2 5	Хачигт халдвар илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	120,000
1.5.2 6	БЗДХ-ын үндсэн 3 үүсгэгч илрүүлэг: Chlamydia trachomatis (CT), Neisseria gonorrhoeae (NG), Ureaplasma urealyticum (UU)	бх-ПГУ/Real-time PCR	85,000
1.5.2 7	Хүний дархлал хомсдолын вирус ДНХ илрүүлэг (HIV)	бх-ПГУ/Real-time PCR	85,000
1.5.2 8	Хламид ДНХ илрүүлэх Chlamydia trachomatis (CT)	бх-ПГУ/Real-time PCR	63,000
1.5.2 9	Нейссерия гонореи ДНХ илрүүлэх Neisseria gonorrhoeae (NG)	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.5.3 0	Эбштейн-Барр вирусийн ДНХ илрүүлэх (Epstein Barr virus)	бх-ПГУ/Real-time PCR	100,000
1.5.3 1	Микоплазмын ДНХ илрүүлэх Mycoplasma genitalium (MG)	бх-ПГУ/Real-time PCR	50,000
1.5.3 2	Микоплазмын ДНХ илрүүлэх Mycoplasma hominis (MH)	бх-ПГУ/Real-time PCR	50,000
1.5.3 3	Уреоплазмын ДНХ илрүүлэх Ureaplasma urealyticum (UU)	бх-ПГУ/Real-time PCR	50,000
1.5.3 4	Уреоплазмын ДНХ илрүүлэх Ureaplasma parvum (UP)	бх-ПГУ/Real-time PCR	50,000
1.5.3 5	Herpes simplex virus type 1 (HSV1) илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	55,000
1.5.3 6	Herpes simplex virus type 2 (HSV2) илрүүлэх	бх-ПГУ/Real-time PCR	55,000
1.5.3 7	Хүний папилома вирусийн дезоксирибонуклейн хүчил илрүүлэх өндөр эрсдэлтэй 15 төрлийн генотип тодорхойлох шинжилгээ (HPV DNA:16,18,39,31,33,58,45,59,51,66,52,53,56,68,35)	бх-ПГУ/Real-time PCR	230,000
1.5.3 8	Цитомегаловирусийн ДНХ илрүүлэх Cytomegalavirus (CMV)	бх-ПГУ/Real-time PCR	121,000
1.5.3 9	Treponema pallidum (TP) илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	110,000
1.5.4 0	Varicella zoster вирус (VZV) илрүүлэг	бх-ПГУ/Real-time PCR	55,000
1.5.4 1	БЗДХ-ын 4 үүсгэгчийн илрүүлэг: Chlamydia trachomatis (CT), Neisseria gonorrhoeae (NG), Trichomonas vaginalis (TV), Mycoplasma genitalium	бх-ПГУ/Real-time PCR	95,000

	(MG)		
1.5.4 2	Нейссерия гонорейн антибиотикийн тэсвэржилт: (Neisseria gonorrhoeae (NG) Azythromycin, Ciprofloxacin-д мэдрэг чанар тодорхойлох)	бх-ПГУ/Real-time PCR	120,000
1.5.4 3	Микоплазмын антибиотикийн тэсвэржилт: (Mycoplasma genitalium Azithromycin-д мэдрэг чанар тодорхойлох)	бх-ПГУ/Real-time PCR	120,000
<b>1.6 Шимэгч судлалын шинжилгээ</b>			
1.6.1	Rickettsia IgG	Elisa	20,000
1.6.2	Rickettsia IgM	Elisa	20,000
1.6.3	Хачигт боррелиозын IgM илрүүлэг	Elisa	20,000
1.6.4	Хачигт боррелиозын IgG	Elisa	20,000
1.6.5	Хачигт энцафалитын IgM илрүүлэг	Elisa	20,000
1.6.6	Хачигт энцафалитын IgG	Elisa	30,000
1.6.7	Echinococcus IgG илрүүлэг	Elisa	20,000
1.6.8	Токсоплазмоз IgG илрүүлэг	Elisa	20,000
1.6.9	Шимэгч хорхойн өндөг илрүүлэх	Натив харах	5,000
1.6.1 0	Шимэгч хорхойн өндөг илрүүлэх	Хурдавчилсан оношлуур	15,000
1.6.1 1	Маларийн эсрэг IgG	Elisa	12,000
1.6.1 2	Taenia solium IgG	Elisa	13,000
1.6.1 3	Шимэгч судлал баталгаажуулах шинжилгээ	Бичил харуур	25,000
1.6.1 4	Гэдэсний шимэгчийн үндсэн 6 үүсгэгч Allplex GI-Parasite Assay	бх-ПГУ/Real-time PCR	140,000
1.6.1 5	Шимэгч хорхойн үндсэн 9 үүсгэгч Allplex GI-Helminth Assay	бх-ПГУ/Real-time PCR	140,000
1.6.1 6	Хачигт халдварын үндсэн 9 үүсгэгч Novaplex TM Tick-borne Disease Assay (RUO)	бх-ПГУ/Real-time PCR	120,000
<b>1.7 Сүрьеэ илрүүлэх шинжилгээ</b>			
1.7.1	Хүчилд тэсвэртэй савханцар илрүүлэх, гэрлийн микроскоп	Цель-Нильсен	15,000
1.7.2	Хүчилд тэсвэртэй савханцар илрүүлэх, флюоресцент микроскоп	Аурамин	15,000
1.7.3	Микобактери илрүүлэх болон РИФ тэсвэржилт тодорхойлох	бх-ПГУ/Real-time PCR, Хpert MTB/RIF (ultra)	35,000
1.7.4	Хүчилд тэсвэртэй нян өсгөвөрлөх	Шингэн тэжээлт орчинд /BACTEC MGIT	45,000
1.7.5	Хүчилд тэсвэртэй нян өсгөвөрлөх	Хатуу тэжээлт орчинд	21,000
1.7.6	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох	бх-ПГУ/Real-time PCR	80,000



1.7.7	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: Сүрьеэгийн эсрэг 1-р эгнээний эмэнд (HRES)	Хатуу орчинд	тэжээлт	55,000
1.7.8	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: Сүрьеэгийн эсрэг 1-р эгнээний эмэнд (HRES)	Шингэн орчинд MGIT/	тэжээлт /BACTEC	75,000
1.7.9	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: Сүрьеэгийн эсрэг 2-р эгнээний эмэнд	Хатуу орчинд	тэжээлт	75,000
1.7.10	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: Сүрьеэгийн эсрэг 2-р эгнээний эмэнд	Шингэн орчинд MGIT/	тэжээлт /BACTEC	75,000
1.7.11	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: (M.tuberculosis complex INH and RIF)	PCR - Genotype MTBDR plus		50,000
1.7.12	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: (M.tuberculosis complex RQ and Inject)	PCR - Genotype MTBDRsl		50,000
1.7.13	Эмэнд мэдрэг чанар тодорхойлох: (nontuberculous mycobacteria, macrolides and AG)	PCR - Genotype NTM-DR		50,000
1.7.14	АДА фермент тодорхойлох	BS-230 chemisty		15,000
1.7.15	Интерферон гамма тодорхойлох	ELISA		250,000
<b>1.8 Эмгэг судлалын шинжилгээ</b>				
1.8.1	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	Эмгэг судлал		106,000
1.8.2	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх FNA	Эмгэг судлал		50,000
1.8.3	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (ясны эд)	Эмгэг судлал		66,000
1.8.4	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (зөөлөн эд, бүх терлийн дурангаар авсан эд)	Эмгэг судлал		40,000
1.8.5	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	Эмгэг судлал		48,000
1.8.6	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (мэс ажилбараар авсан эд)	Эмгэг судлал		79,000
<b>1.9 Лабораторийн дэмжлэгт тусламж, үйлчилгээ</b>				
1.9.1	Лабораторийн сургалт	Мэргэжлийн лекц, онлайн, дадлага сургалт /1 цаг/		100,000
1.9.2	Лабораторийн ажлын байрны дэмжлэгт үнэлгээ	Лабораторийн стандарт, үйл ажиллагаа, чанар, био-аюулгүй ажиллагаатай холбоотой мэргэжлийн дэмжлэг		100,000
1.9.3	Оношлуурын үнэлгээ хийх	Үнэлгээний хелс		500,000

	Үнэлгээнд хэрэглэгдэх сорьц, урвалж оношлуур, шинжилгээний зардлыг тус тушаал дахь үнээр тооцож үйлчлүүлэгч төлнө	
	Үнэлүүлэх оношлуурыг үйлчлүүлэгч хариуцна	


№	Тусламж, үйлчилгээний жагсаалт	Тариф
		Сангийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалд заагдсан болон нэмэлт тусламж, үйлчилгээ
<b>Хоёр. Амбулаторын тусламж үйлчилгээ</b>		
<b>2.1</b>	<b>Дурангийн кабинетийн тусламж үйлчилгээ</b>	
2.1.1	Унтуулгатай уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)	100,000
2.1.2	Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)	70,000
2.1.3	Элэгний хатуурал тодорхойлох Фиброскан шинжилгээ	20,000
2.1.4	Хэт авиан хяналтанд хийх нарийн зүүний хатгалт, биопси (Бамбай, хөх, зөөлөн эд)	80,000
<b>Ажилбар</b>		
2.1.4	Хурц цус алдалтад тариа хийх дурангийн эмчилгээ	120,000
2.1.5	Шарханд тариа хийх дурангийн эмчилгээ	100,000
2.1.6	Хавчаар (клип)тавих (Хэрэглэсэн нэг удаагийн клип бүрийн үнэ ширхэгээр үнэлэгдэж нэмэгдэнэ)	200,000
2.1.7	Хавчаар (нэг удаагийн клип)	60,000
2.1.8	Цахилгаан түлэлт	200,000
2.1.9	Улаан хоолойн өргөссөн венийн судас боох	450,000
2.1.10	Гадны биетийг авах (Тухайн нөхцөлд хэрэглэгдэх багажаас хамааран үнэ хэлбэлзэнэ)	150,000
2.1.11	Ургацаг авах	150,000
2.1.12	Бронхосанац	50,000
2.1.13	Дурангийн унтуулга	30,000
<b>2.2</b>	<b>Зүрх, судасны оношлогооны кабинетийн тусламж, үйлчилгээ</b>	
2.2.1	Зүрхний цахилгаан бичлэг	9,000
<b>2.3</b>	<b>Хэт авиан оношилгоо</b>	
2.3.1	Хэвлийн эрхтнүүдийн хэт авиан	15,000

	оношилгоо	
2.3.2	Бамбай булчирхайн хэт авиан оношилгоо	15,000
2.3.3	Эмэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо	15,000
2.3.4	Төмсөгний хэт авиан оношлогоо	15,000
<b>2.4</b>	<b>Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ</b>	
2.4.1	Дүрс оношилгооны хальс дахин хэвлүүлэх	10,000
2.4.2	Дүрс оношилгооны зураг CD-нд дахин буулгах	2,500
2.4.3	Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	10,000
2.4.4	Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000
2.4.5	Рентген харалт (Цээж, хэвлий)	10,000
2.4.6	Рентгений хяналтанд хийх ажилбар	60,000
2.4.7	Хоол боловсруулах замын баритай шинжилгээ (Улаан хоолой, ходоод, дээд гэдэс, бүдүүн шулуун гэдэс)	60,000
2.4.8	Ясны сийрэгжилтийн шинжилгээ (Остеоденситометрия)	33,000
<b>2.5</b>	<b>Компьютер томографийн оношилгоо (СТ)</b>	
2.5.1	Нэг байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томографи	90,000
2.5.2	Нэг байрлалд хийх тодосгогчтой компьютерт томографи	240,000
2.5.3	Олон байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томографи	120,000
2.5.4	Олон байрлалд хийх тодосгогчтой компьютерт томографи	270,000
<b>2.7</b>	<b>Чих хамар хоолойн тусламж, үйлчилгээ</b>	
2.7.1	Хамрын өмнөд чихээс хийх	10,000
2.7.2	Хамрын шинэ гэмтэл засах	150,000
2.7.3	Хамрын самалдагт тариа тарих (нэг удаа)	15,000
2.7.4	Хамрын хатиг нээх	50,000
2.7.5	Хамрын дайвар хөндийг угааж соруулах	25,000
2.7.8	Чихний хатиг нээх	30,000
2.7.9	Чихний хулхи угаах	10,000
2.7.10	Чихний сэтэрхий оёх (нэг чих)	30,000
2.7.11	Тагнайн гүйлс орчмын буглааг нээх	100,000

2.7.12	Төвөнхөд эм дусаах (нэг удаа)	5,000
2.7.13	Төвөнхийн хэсэг газрын эмчилгээ (1 удаа)	5,000
2.7.14	Сонсголын бичлэг	10,000
<b>2.8</b>	<b>Физик эмчилгээний тусламж, үйлчилгээ</b>	
2.8.1	Нүүрний саажилтийн үед зүү эмчилгээ (5 удаа)	50,000
2.8.2	Лазер-туяа эмчилгээ (5 удаа)	25,000
2.8.3	УВЧ (5 удаа)	20,000
2.8.4	Электрофорез (5 удаа)	20,000
2.8.5	Солюкс (5 удаа)	15,000
2.8.6	Бумба (5 удаа)	15,000
2.8.7	Зүү эмчилгээ (5 удаа)	50,000
2.8.8	Теене эмчилгээ (5 удаа)	15,000
2.8.9	Гэрлэн банн (5 удаа)	25,000
2.8.10	Цөс цэвэрлэх (1 удаа)	10,000
2.8.11	Шивүүр (1 удаа)	20,000
2.8.12	Ходоод угаах	7,000
2.8.13	Клизм тавих	2,500
<b>Гурав. Бусад</b>		
3.1	Эмчийн үзлэг	20,000
3.2	Ахлах, тэргүүлэх болон клиникийн профессор эмчийн үзлэг	25,000
3.3	Гавьяат эмч, АУ-ын доктор, зөвлөх эмчийн үзлэг	35,000
3.4	Донтолт, архидалт, мансуурдаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ	Тусламж үйлчилгээнийг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
3.5	Иргэн санаатайгаар амь насаа өгүүтгэхээр оролдсон тохиолдлын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Тусламж үйлчилгээнийг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
3.6	Даатгал болон төр хариуцдаггүй шинээр нэвтэрч буй технологийн шинэчлэлт хийгдсэн тусламж, үйлчилгээ	Тусламж үйлчилгээнийг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
3.7	Барокамерийн тусламж, үйлчилгээ /нэг удаа/	45,000
3.8	Гуурсан хоолой сэдээх метахолинтой сорил (спирограмм)	80,000
3.9	Гуурсан хоолойн эмтэй сорил (Тэлэх, метахолинтой) спирограмм	30,000
3.10	Спирограмм	16,000
<b>Ажил, сургуульд орох, гадаадад явах, гэр бүл батлуулах, жолооны үнэмлэх авахад шаардагдах эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ</b>		
3.7	Жолооны үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	50,000
3.8	Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	80,000

3.9	Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	80,000
<b>Гемодиализ</b>		
3.10	Гемодиализ (Дан эмчилгээ)	125,000
3.11	Хэвлийн диализ	55,000
<b>Дөрөв. Нэмэлт үйлчилгээ</b>		
<b>Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ</b>		
4.1	Захиалгат хоол	5,000-15,000
<b>Шарил хадгалах, тээвэрлэх үйлчилгээ</b>		
4.2	Шарил хадгалах үйлчилгээ (нэг хоногт, эмнэлгийн нас баралтаас бусад тохиолдолд)	28,000
4.3	Шарил тээвэрлэх үйлчилгээ (1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд)	3,000
<b>Захиалгат ариутгал, угаалга</b>		
4.4	Бикс, боодол (том, дунд, жижиг)	15,000
4.5	Дезкамер (матрас, гудас, хөнжил, дэр, гадар даавуу)	4,500
4.6	Ширхэгээр, дотуур хувцас угаалга	4,000
4.7	Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, мэрэгчгүйтэл, шавжгүйтгэл /м2/	450
<b>Өвчтөн тээвэрлэх</b>		
4.7	Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд	2,000
<b>Баримт авах</b>		
4.8	Төлбөрийн баримт дахин хэвлүүлж, хуулбарлан авах	2,500
4.9	Амбулаторын карт	2,500
<b>Хурлын танхим</b>		
4.10	Хурлын танхим (1 цаг)	100,000
<b>Хувцасны өлгүүр</b>		
4.11	Өлгүүрийн дугаар гээгдүүлэхэд төлөх төлбөр	2,500
<b>Эмч дуудлага</b>		
4.12	Эмч дуудлагын хөлс	20,000

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 08 дүгээр сарын 09 өдрийн  
А/ тоот тушаалын гуравдугаар хавсралт  
184



ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ГАДААД ХЯНАЛТЫН ЖАГСААЛТ, ТАРИФ

Д/д	Хяналтын материалын нэр, төрөл	Шинжилгээний арга	Төлбөрийн хэмжээ
1	Хепатит В вирус	Ийлдэс судлал	100,000
2	Хепатит С вирус	Ийлдэс судлал	100,000
3	ХДХВ/ДОХ	Ийлдэс судлал	100,000
4	Тэмбүү	Ийлдэс судлал	100,000
5	Дельта вирус хяналтын багц	Ийлдэс судлал	100,000
6	HBV-DNA хяналтын багц	NAAT	600,000
7	HCV-RNA хяналтын багц	бх-ПГУ/Real-time PCR	600,000
8	HDV-RNA хяналтын багц	бх-ПГУ/Real-time PCR	600,000
10	Сүрьеэ, Ур чадварын сорилын багц (10 ширхэг наац)	Түрхэцийн шинжилгээ	150,000
11	Сүрьеэ, нэг түрхэц давтан шалгах	Түрхэцийн шинжилгээ	5,000
12	Нян судлалын хяналтын багц (1 есгөвөр нь)	Бичил биетэн есгөвөрлөж, ялган дүйж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох	100,000
13	Томуугийн хяналтын багц	бх-ПГУ/Real-time PCR	100,000
14	Ковид-19 (SARS-CoV-2) вирусын хяналтын багц	бх-ПГУ/Real-time PCR	100,000




ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 08 дүгээр сарын 09 өдрийн  
#1/184 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ НЭГЖИЙН АЖИЛЛАХ ОР, НӨХЦӨЛ САЙЖРУУЛСАН  
ОРНЫ ТОО, МӨРДӨХ ТАРИФ

Д/д	Тасгийн нэр	Төсөвт орны тоо	Нөхцөл сайжруулсан орны тоо	Нэг ор хоногийн төлбөр
1.	1-р тасаг	45	4	50,000
2.	2-р тасаг	30	3	10,000
3.	3-р тасаг	20	2	10,000
4.	4-р тасаг	35	3	10,000
5.	5-р тасаг	50	5	10,000
6.	6-р тасаг	50	5	10,000
7.	7-р тасаг	50	5	20,000
8.	8-р тасаг	60	6	10,000
9.	Уушиг-1	35	3	10,000
10.	Уушиг-2	35	3	10,000
11.	Хүүхэд	34	3	10,000
12.	Олон эмийн дасалт сүрьеэгийн тасаг 1	30	3	10,000
13.	Олон эмийн дасалт сүрьеэгийн тасаг 2	30	3	10,000
14.	Мэс засал	30	3	10,000
15.	Сүрьеэгийн эрчимт эмчилгээ	12	2	60,000
16.	Халдвартын эрчимт эмчилгээ	10	2	60,000

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 08 дүгээр сарын 19 өдрийн  
#1184 тоот тушаалын тавдугаар хавсралт



## АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГАТАЙ ГЭРЭЭГЭЭР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН ЗОРИЛГО

1.1 Эрүүл мэндийн хуулинд заасан хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнуудыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдлийг эрт илрүүлэх, оношлох нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж, сургалт сурталчилгаа зохион байгуулах, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР. ҮЗЛЭГ ХИЙХ ЖУРАМ

2.1 Урьдчилан сэргийлэх үзлэгийг захиалагч байгууллагын хүсэлтийг харгалзан тухайн байгууллагад болон өөрийн эмнэлгийн байранд хийнэ.

2.2 Урьдчилан сэргийлэх үзлэг хийхийн өмнө захиалагч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулна.

2.3 Захиалагч байгууллагын хүсэлтийг харгалзан үзлэг, оношилгооны нэр төрлийг Амбулаторийн эрхлэгч товлон төлбөрт тусламж, үйлчилгээний журамд батлагдсан үнийн тарифын дагуу гэрээнд тусгана.

2.4 Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтийг Амбулаторийн эрхлэгч гаргана. Эрүүлжүүлэх хөтөлбөр боловсруулж тухайн байгууллагатай хамтарч ажиллана.

2.5 Амбулаторийн эрхлэгч үзлэгийн тайланг нэгтгэн тухайн үзлэгт хамрагдсан байгууллага болон санхүүгийн албанд тайлагнана.

### ГУРАВ. ГЭРЭЭТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ АЖИЛЛАХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ

3.1 Үзлэгийг тогтоосон хугацаанд чанартай, түргэн шуурхай хийж үйлчилнэ.

3.2 Үзлэгийн мэдээ, тайланг хугацаанд нь гарган ажиллана.

### ДӨРӨВ. ҮЗЛЭГ ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Захиалагч байгууллага нь ажилтан, албан хаагчдыг гэрээнд заасан хугацаанд нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах шаардлагатай бэлтгэлийг хангана.

4.2 Ажилтан, албан хаагчдын нэрсийг гаргаж, эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг тогтоосон загварын дагуу бэлтгэн олшруулна.

4.3 Үзлэгт хамрагдсан ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн дүгнэлтийг гаргуулж авна.

### ТАВ. ГЭРЭЭТ ҮЗЛЭГИЙН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

5.1 Иргэн өөрөө нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдах тохиолдолд тухайн кабинетийн даатгалаас нэхэмжилдэг тарифаар тооцогдоно.

5.2 Нэмэлт лабораторийн шинжилгээний тарифыг эмнэлгийн төлбөрт тусламж, үйлчилгээний тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан тарифаар тооцно.

5.3 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажилтны тоо, сонгосон үзлэг, шинжилгээний нэр төрлөөс хамаарч тухайн байгууллагатай "урьдчилан сэргийлэх үзлэгийн багцын тариф" шинэчлэн гаргаж гэрээгээр гүйцэтгэж болно.

5.4 Урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөрийн 30 хувийг үзлэгийн өмнө байгууллагын дансанд эсвэл кассанд бэлнээр тушааж үзлэг дууссанаас хойш тайланг үндэслэн гүйцэтгэл болон гэрээ дүгнэсэн актаар төлбөрийг дуусгана.

5.5 Гэрээт урьдчилан сэргийлэх үзлэгээс олсон орлогыг байгууллагын төсөвт төвлөрүүлнэ.